



ГОВЬСУМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 10 өдөр

Дугаар A/57

Шивээговь сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 59.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 46.1.3, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын 2023 оны “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн хөрөнгөөр хийгдэх “Боловсролын байгууллагын сургалтын хэрэглэгдэхүүнд тоног төхөөрөмжид шинэчлэлт хийх” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

Ш.Буяннэмэх

(Соёлын төвийн номын санч)

Гишүүд:

А.Солонгоо

(“Шивээ Сервис” ХХК ХАБ инженер)

О.Отгонбаяр

(Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн)

Ж.Баярцэцэг

(Иргэний төлөөлөл)

Нарийн бичгийн дарга:

Б.Алтансүх

(Хөрөнгө оруулалт, эдийн засаг төлөвлөлт, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

2. Боловсролын байгууллагын сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжид шинэчлэлт хийх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг хуулийн дагуу хариуцлагатай зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг үнэлгээний хорооны дарга (Ш.Буяннэмэх)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА *Ганчимэг* П.ГАНЧИМЭГ



42123 183